

Үндэсний хөгжлийн газрын даргын  
2020 оны 96 сарын 13-р сарийн 12-гоот  
тушаалын ... хавсралт.

## УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

УХА0588  
6098177  
116127253

- 1.1 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газраас баталсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам"-ын дагуу боловсруулах ба уг журамд заасан хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахад энэхүү аргачлалыг мөрдөнө.
- 1.2 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид УХОХ гэх/-т тусгах хөрөнгө оруулалтын төсөл нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, 1-ээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл байна.
- 1.3 УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төсөл нь улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээ, Хөгжлийн банк, гадаад, дотоод хөрөнгө оруулалтт зэрэг санхүүжилтийн их үүсүүрүүр хэрэгжинэ.
- 1.4 УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төсөл нь энэхүү аргачлал болон бусад холбогдох аргачлал, удирдамжийн дагуу боловсруулсан, баримт бичгийн иж бүрдэл, төсөлд тавигдах шаардлагыг хангасан, санхүү, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой болох нь нотлогдсон байна.
- 1.5 Энэхүү аргачлал, түүнийг дагалдах гарын авлагын дагуу боловсруулсан төслийн санал болон төслийн саналтай хамт ирүүлсэн төслийн баримт бичгийн иж бүрдэлд тусгагдсан мэдээлэл нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг (цаашид "төсөл" гэх) үнэлэх, эрэмбэлэх, сонгоход ашиглагдах үндсэн мэдээлэл болно.
- 1.6 УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн саналын маягтыг хэрхэн бөглөхийг тайлбарласан заавар болох "Төслийн санал бэлтгэх зааварчилгаа" нь энэхүү аргачлалын салшгүй нэг хэсэг юм.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно.

Үүнд:

- "улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг хэлнэ.
- "төслийн төлөвлөлт" гэж тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тулд шаардагдах бүтээн байгуулалт болон ашиглалтын үйл ажиллагааны агуулга, хэрэгжих хугацаа, төсөвт өртөг, хүний нөөц, дэд бүтцийн хэрэгцээг нарийвчлан тусгасан, холбогдох судалгаа, тусгай зөвшөөрөл, зардал үр ашгийн тооцоо бүхий эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, учирч болох эрсдэл зэргийг цогцоор нь тодорхойлсон төлөвлөлтийн бичиг баримтыг хэлнэ.
- "төслийн санал" гэж энэхүү аргачлалын Хавсралт 1-10-т үзүүлсэн маягтын дагуу бэлтгэсэн хөрөнгө оруулалтын төслийн танилцуулгыг хэлнэ.

- “шинээр хэрэгжих төсөл” гэдэг нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шинээр туссан, тухайн хэрэгжилтийн жилээс эхлэн хэрэгжих төслийг хэлнэ.
- “шинээр тусгах төсөл” гэдэг нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар санал гарган, төслийг үнэлэх, эрэмбэлэх аргачлалын дагуу сонгогдсон төслийг хэлнэ.
- “шилжин хэрэгжих төсөл” гэдэг нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өмнө нь туссан бөгөөд хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээгээр хэвийн үргэлжилж буй нь тогтоогдсон, тодотголд тусгахаар шийдэгдсэн төслийг хэлнэ.
- “дахин үнэлэх төсөл” гэдэг нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт өмнө нь туссан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээгээр төслийн үйл ажиллагаа нь “эргэлзээтэй буюу дахин үнэлэх” гэж дүгнэгдсэн төслийг хэлнэ.

## **ГУРАВ. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 3.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төсөл нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - Эрэлт хэрэгцээ, шаардлагад үндэслэсэн байх;
  - Улс, салбар, бүс орон нутгийн хөгжлийн урт болон дунд хугацааны бодлоготой нийцсэн, бодлогын барим бичигт туссан тодорхой зорилтыг хангахад чиглэсэн байх;
  - Нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашигтай нь нотлогдсон байх;
  - Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартын шаардлагыг хангасан байх;
  - Техник технологийн түвшнийг үнэлсэн, салбарын хөгжилд үзүүлэх нөлөөллийг тооцсон байх;
  - Санхүү, эдийн засгийн шинжилгээ хийж, хөрөнгө оруулалтын өгөөжийг тодорхойлсон байх;
  - Эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийсэн байх;
  - Шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэрийн саналыг үндэслэлтэй тодорхойлсон байх;
  - Төслийг хэрэгжүүлэх үндэслэлтэй, хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулсан байх;
  - Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээлэл, судалгаа, нотлох баримтад сууринласан байна.
- 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төслийн баримт бичгийг боловсруулах ба уг баримт бичиг болон холбогдох бусад мэдээ, мэдээлэл, тооцоо, судалгааны үнэн зөв, бодитой байдлыг бүрэн хариуцна.
- 3.3 Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллага нь дээрх шаардлагуудыг хангаагүй хөрөнгө оруулалтын төслийг дахин боловсруулах, нэмэлт сайжруулалт хийхийг санал болгон төсөл санаачлагчид буцаана.

## **ДӨРӨВ. ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ, ТҮҮНИЙГ БОЛОВСРУУЛЖ, ХҮРГҮҮЛЭХ**

- 4.1 Аргачлалын 2.1.3 буюу төслийн санал, бусад холбогдох материалын хамт нийтэд нь “Төслийн баримт бичиг” гэх ба төсвийн ерөнхийлөн захирагч боловсруулна .
- 4.2 “Төслийн баримт бичиг” нь хөрөнгө оруулалтын төсөл тус бүрээр дараах иж бүрдлийг хангасан байна. Үүнд:
  - 4.2.1. Төслийн товч танилцуулга - Төслийн гол агуулга, ач холбогдол, төслийн хүрээнд хийгдэх болон хийгдсэн ажлуудыг багтаан танилцуулна.
  - 4.2.2. Төслийн судалгаануудын хураангуй - Төсөл хөгжүүлэлтийн хүрээнд өмнө нь

- хийгдсэн судалгаануудын /суурь судалгаа, ТЭЗУС, ТЭЗҮ, БОНБҮ г.м./ хураангуй танилцуултыг 30 хүртэл хуудсанд багтаан бэлтгэнэ.
- 4.2.3. Төслийн санал - Энэхүү аргачлалын Хавсралт 1-10 дугаар маягтуудыг "Төслийн санал бэлтгэх" зааварчилгааны дагуу бөглөсөн байна.
- 4.2.4. Төслийн үнэлгээний дүгнэлт – Төслийн саналыг "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал"-ын дагуу үнэлж, эрэмбэлэн, дүгнэлт гаргасан байна.
- 4.2.5. Бусад тооцоо судалгаа, мэдээ, мэдээлэл, холбогдох тогтоол, шийдвэр, мэргэжлийн байгууллагын дүгнэлтүүдийг оруулна.
- 4.3 Төсвийн ерөнхийлөн захирагч нь Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад саналаа ирүүлэхдээ төсөл тус бүрээр боловсруулсан "Төслийн баримт бичиг"-ийг дараах бичиг баримтын хамт хүргүүлнэ.
- Сайдын/даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл – Төсвийн ерөнхийлөн захирагч нь сайдын/даргын зөвлөлөөр хөрөнгө оруулалтын төсөл нэг бүрийг УХОХ-т тусгуулахаар санал хүргүүлэх эсэхийг хэлэлцүүлэн нэгдсэн шийдвэрт хүрсэн байна.
  - Салбарын өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн тайлан - Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн хариуцаж буй салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд УХОХ-т тусгуулахаар хүргүүлж буй төслийн саналууд хэрхэн нөлөөлөх зэргийг, тайлангийн танилцуулгад дурьдаж, танилцуулга хүргүүлнэ. Тайлангийн танилцуулгыг бэлтгэхдээ салбарын болон дэд салбаруудын тайланг өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэл гаргаж болно.
- 4.4 Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шаардлагатай тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн төслийн баримт бичиг дээр нэмж тодруулга, нэмэлт материал, мэдээ, мэдээлэл авч болно.
- 4.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Төслийн баримт бичиг"-ээ Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхийн өмнө "Хөрөнгө оруулалтын төслийн нэгдсэн мэдээллийн сан, цахим системийн гарын авлагы"-ыг ашиглан цахим системд оруулсан байна.
- 4.6 Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагчдад хөрөнгө оруулалтын төслийн нэгдсэн мэдээллийн сан, цахим системд хандах хандалтын эрхийг нээнэ.
- 4.7 Төсвийн ерөнхийлөн захирагчдын УХОХ-т тусгуулахаар ирүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг "Шинээр хэрэгжих төсөл", "Шилжин ирэх төсөл" гэж хуваан авч үзнэ.
- 4.8 "Шинээр хэрэгжих төсөл"-д дараах төслүүдийг хамруулна. Үүнд:
- 4.8.1. УХОХ эсхүл түүний өмнөх жилийн тодотголд тусгагдаагүй, шинээр тусгуулахаар санал болгож буй төсөл;
  - 4.8.2. УХОХ эсхүл түүний өмнөх жилийн тодотголд тусгагдсан ч дараагийн жилүүдээс хэрэгжиж эхлэхээр төлөвлөгдсөн төсөл;
  - 4.8.3. УХОХ эсхүл түүний өмнөх жилийн тодотголд тусгагдсан ч санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэгдээгүй эсхүл эх үүсвэр шийдвэрлэгдсэн ч санхүүжилт хийгдээгүйн улмаас хэрэгжих хугацаа нь хойшлогдсон төсөл;
- 4.9 "Шилжин хэрэгжих төсөл"-д дараах төслүүдийг хамруулна. Үүнд:
- 4.9.1 Өмнөх жилийн УХОХ-т тусгагдсан бөгөөд хэрэгжиж буй төслүүд;
  - 4.9.2 Өмнөх жилийн УХОХ-т тусгагдсан, тухайн жилд эхлэх төлөвлөгөөтэй санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн хэдий ч үйл ажиллагаа нь эхлээгүй төсөл;
  - 4.9.3 Өнөөг хүртэл УХОХ-т тусгагдаагүй байсан 30 тэрбум төгрөгөөс дээш

- өртөгтэй, үйл ажиллагаа нь эхэлсэн төсөл (эсхүл УХОХ-ийн тодотгол хийх үед "шилжин ирэх төсөл" гэсэн тодотголтой)
- 4.10 Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Шинээр хэрэгжих төсөл"-ийн хувьд дараах байдлаар Төслийн баримт бичгийг бэлтгэн хүргүүлнэ. Үүнд:
- 4.8.1-д хамаарах төслүүдийн хувьд "Төслийн баримт бичиг"-г иж бүрнээр нь ирүүлэх ба түүний нэг Бүрэлдэхүүн хэсэг болох "Төслийн санал"-аа энэхүү аргачлалын дагуу боловсруулсан байх;
  - 4.8.2 ба 4.8.3-д хамаарах төслүүдийн хувьд "Төслийн баримт бичиг"-г иж бүрнээр нь ирүүлэх шаардлагагүй боловч төслийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол холбогдох хавсралтыг шинэчилж ирүүлэх;
  - 4.8.3-д хамаарах төслүүдийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол өөрчлөгдсөн мэдээллийг ирүүлэхээс гадна санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой нөхцөл байдлыг тодорхойлон, шийдвэрлэх арга замын талаарх саналаа хавсаргах;
- 4.11 Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Шилжин хэрэгжих төсөл"-ийн хувьд дараах байдлаар Төслийн баримт бичгийг бэлтгэн хүргүүлнэ. Үүнд:
- Хэрэв тухайн төсөлд дахин үнэлгээ хийгдэх бол шинээр тусгах төслийн адилаар "Төслийн баримт бичиг"-г иж бүрнээр нь бэлтгэн ирүүлэх;
  - Хэрэв тухайн төсөл хэвийн үргэлжилж байгаа бол "Төслийн баримт бичиг"-г иж бүрнээр нь ирүүлэх шаардлагагүй боловч төслийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол түүнийгээ баталгаажуулах;
- 4.12 Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүр УХОХ-ийн өөрийн багцад туссан бүх төслүүдийн цахим систем дэх мэдээллийг шинээр хэрэгжих, шилжин хэрэгжих аль нь байхаас үл хамааран шинэчилж байна.
- 4.13 Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн материалыг нягтлан шалгаж дараах тохиолдлуудад хүлээн авахаас татгалзана. Үүнд:
- Аргачлалын 4.2-т заасан "Төслийн баримт бичиг" –ийн иж бүрдэл дутуу;
  - "Төслийн санал" нь холбогдох зааврын дагуу бүрэн, үнэн зөв бэлтгэгдээгүй;
  - Энэхүү аргачлалын 4.3-т заасан бичиг баримтуудыг ирүүлээгүй.

#### **ТАВ. ТӨСЛИЙН САНАЛ, ТҮҮНИЙГ БОЛОВСРУУЛАХ**

- 5.1. УХОХ-т шинээр тусгах төсөл нь хэрэгжиж эхлээгүй төсөл байх ба төлөвлөлтийн дараах 4 үндсэн үе шатны алинд нь ч хамаарч болно. Үүнд:
- Суурь судалгаа хийх – энэ үе шатанд төсөл хэрэгжих орчин, нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлын суурь судалгаа, төслийн хэрэгцээ, шаардлага, үндэслэл, төслөөр шийдвэрлэх асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн өөрийн орны болон гадаад орнуудын туршлага болон төслийн үндсэн шийдлүүдийн суурь судалгааг хийн, төслийн хэрэгжих боломжтой эсэхийг урьдчилсан байдлаар тодорхойлж, техник эдийн үндэслэлийн урьдчилсан судалгаа хийх буюу төсөл хөгжүүлэлтийн дараагийн шатанд шилжих эсэх дүгнэлтийг гаргана.
  - ТЭЗҮС боловсруулах - энэ үе шатанд төслийн хэрэгцээ, шаардлага, төслийн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн судалгаа хийх шаардлагатай бөгөөд төслийг цаашид нарийвчлан судлах, хэрэгжүүлэх боломжтой эсэх, хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах үндэслэл болно.
  - ТЭЗҮ боловсруулах – энэ үе шатанд төслийг хэрэгжүүлэх хөгжлийн хэрэгцээ, нийгэм эдийн засгийн үндэслэл, хууль эрх зүйн орчин, зах зээл, хүний нөөцийн

- чадавх, дэд бүтцийн хүчин чадал, хангамж зэргийг нарийвчлан судалж, төхник технологийн шийдэл, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, байр талбайн хэрэгцээнд тулгуурлан төслийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцоолж, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, ажиллах хүч, түүхий эд, зардлын хэмжээ, олох ашиг, санхүү үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн шинжилгээ, байгаль орчны төлөв байдлын шинжилгээ, инженер геологийн судалгаа зэрэг нарийвчлсан судалгаануудыг хийн төслийг хэрэгжүүлэх хувилбаруудыг тодорхойлно.
- Зураг төсөв болон бусад нарийвчилсан судалгааг хийх – энэ шатанд инженер геологийн дүгнэлт, архитектур төлөвлөлтийн зураг, эскиз зураг, иж бүрэн ажлын зураг болон хийцийн холбогдох бусад тооцоог тодорхойлно. Зураг төслийн баримт бичиг болон барилгын бүтээц ажлын төрлөөрх суурь нормыг үндэслэн барилгын төсөвт өртгийг тодорхойлно.
- 5.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн төсөл хөгжүүлэлтийн аль үе шатанд байгаагаас үл хамааран төсөл тус бүрээр "Төслийн санал" боловсруулах ба энэ нь төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавихад ашиглах үндсэн баримт бичиг болно.
- 5.3. "Төслийн санал"-ийг энэхүү аргачлалын Хавсралт 1-10-т үзүүлсэн маягуудыг ашиглан "Төслийн санал бэлтгэх зааварчилгаа"-ны дагуу, тухайн төслийн талаар иж бүрэн, дэлгэрэнгүй мэдээлэл өгөхүйцээр боловсруулна.
- 5.4. Төслийн санал нь дараах бүтэц, агуулгатай байна. Үүнд:
- 5.4.1. Хавсралт 1. Төслийн үндсэн мэдээлэл – Энэ хэсэгт төслийн нэр, хэрэгжих салбар, дэд салбар, байршил, төслийн үндэслэл, шаардлага, танилцуулга, нийт төсөвт өртөг, хэрэгжих хугацаа, төслийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хэрэгцээ, хэрэгжих боломж, эрсдэлийн талаарх мэдээллийг багтаана.
  - 5.4.2. Хавсралт 2. Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин мэдээлэл – Энэ хэсэгт тухайн төслийн зорилт, зорилго нь хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдах байдал, төсөл хэрэгжих хууль эрх зүйн акт, холбогдох тушаал шийдвэр, тэдгээрийн хүчин төгөлдөр байдлын талаарх мэдээллийг багтаана.
  - 5.4.3. Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө – Энэ хэсэгт төслийн бүтээн байгуулалт болон ашиглалтын шатны төсөв санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт болон эрсдэлийн эсрэг арга хэмжээний талаарх мэдээллийг багтаана.
  - 5.4.4. Хавсралт 4. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт – Энэ хэсэгт төслийн хүрэх үр дүн, суурь түвшин, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээллийг багтаана.
  - 5.4.5. Хавсралт 5. Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл – Энэ хэсэгт ТЭЗУС, ТЭЗҮ, БОНБҮ, инженер геологийн судалгаа, газрын тусгай зөвшөөрөл, эрсдэлийн шинжилгээ зэрэг тоо, баримтанд тулгуурласан, судалгааны мэдээллийг багтаана.
  - 5.4.6. Хавсралт 6. Төслийн дэд бүтцийн хэрэгцээ – Энэ хэсэгт төслийн дэд бүтэц шийдэгдсэн эсэх, эсхүл дэд бүтцийн нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай эсэх зэрэг дэд бүтцийн бэлэн байдлын талаарх мэдээллийг оруулна.
  - 5.4.7. Хавсралт 7. Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ – Энэ хэсэгт төсөл, арга хэмжээ нь төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн мэдлэг боловсролын түвшин, үндэсний үнэт зүйлийг хамгаалахад хэрхэн нөлөөлөх зэрэг нийгмийн ач холбогдол болон ажлын байр бий болгох, бүтээгдэхүүн,

үйлчилгээний хэмжээ, экспортыг дэмжих, импортыг орлох эсэх гадаадын шууд оруулалт татсан эсэх эдийн засгийн үр ашгийн мэдээллийг багтаана.

- 5.4.8. Хавсралт 8. Санхүүгийн шинжилгээ— Энэ хэсэгт төслийн санхүүгийн тооцооллын урьдчилсан нөхцөл, суурь өгөгдлүүдийг тодорхойлж, “Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал”-г ашиглан боловсруулсан анхны хөрөнгө оруулалтын зардал, төсөвт өртөг, төсвийн орлого, зардал, мөнгөн урсгал, санхүүжилтийн хуваарь болон эх үүсвэрийг төлөвлөсөн санхүүгийн бодит тооцооллыг багтаана.
- 5.4.9. Хавсралт 9. Эдийн засгийн шинжилгээ— Энэ хэсэгт “Төслийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал”-г ашиглан тодорхойлсон төслийн нийгэм, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг тусгана.
- 5.4.10. Хавсралт 10. Төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт— Шинээр эхлэх төслийн тухайд ажлын явц гэсэн хэсэгт төслийн зорилго, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түвшний мэдээллийг, санхүүжилтийн гүйцэтгэл хэсэгт нийт төсөвт өртөг, эх үүсвэрийн мэдээллийг тусгана. Шилжин ирэх төслүүдийн хувьд төслийн хэрэгжилтийн явц, болон санхүүжилтийн гүйцэтгэлийг зорилт тус бүрээр тайлagnan, учирч буй саад бэрхшээл, эрсдэл болон нэгдсэн дүгнэлтийг тусгасан байна.
- 5.5. Төслийн санал боловсруулахад анхаарах зүйлс:
- Монгол дүнг сая.тогрогоор илэрхийлэх. Хэрэв төслийн ТСЗУС, ТСЗҮ, санхүүжилтийн гэрээ зэрэг нь бусад валютаар илэрхийлэгдсэн бол тэдгээрийг төгрөгт шилжүүлсэн байх, шилжүүлэхдээ хэзээний ямар ханш ашигласанаа тодорхой оруулсан байх;
  - Боломжит санхүүжилтийн эх үүсвэрийг санал болгоходо тухайн эх үүсвэрээр төсөл санхүүжүүлэхэд тавигдах шаардлагуудыг хангаж буй эсэхийг нягталсан байх;
  - Эрх бүхий байгууллагаас газар эзэмших, ашиглах болон бусад шаардлагатай тусгай зөвшөөрлийг авсан байх;

## ЗУРГАА. ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ

- 6.1. УХОХ-т тусгах төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохдоо Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тус асуудлаар шууд зөвшилцөх уулзалт /цаашид 3 тал гэх/ зохион байгуулна.
- 6.2. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг сонгоходо дараах дүн шинжилгээний үр дүн болон төсвийн ерөнхий шаардлагад нийцүүлнэ. Үүнд:
- Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж;
  - Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;
  - Болзошгүй өр төлбөр болон санхүүгийн бусад эрсдлийн үнэлгээ;
  - Өрийн удирдлагын тухай хууль болон стратегийн баримт бичигт заасан шаардлага;
- 6.3. Төсөл нь санал болгож буй эх үүсвэрийн төрлөөс шалтгаалан дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:
- а. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх:
- Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;
  - “Төсвийн тухай хууль”, “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт,

- хяналт, тайлагналтын журам" болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байх;
- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт багтсан байх;
  - Тухайн салбарт хэрэгжиж буй Үндэсний болон дэд хөтөлбөрт хамаарах буюу суурилсан байх;
  - Тухайн төслийн төрлөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа болон холбогдох аргачлалын дагуу төслийн шинжилгээг хийсэн байх;
  - Тухайн төслийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулсан байх.
- б. Гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлэх
- Арилжааны нөхцөлтэй гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
    - Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;
    - Зээлийн хөрөнгийг эргүүлэн төлөх санхүү, эдийн засгийн чадвартай байх.
  - Засгийн газрын хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
    - Өрийн удирдлагын тухай хуулийн 23.3-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;
    - Нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх чадваргүй төсөл, арга хэмжээг нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх чиглэл баримтлах ба санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх;
- в. Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр санхүүжүүлэх
- Концессын тухай хуулийн 9.4-т заасны дагуу зардал, ашгийн тооцоо хийж, тус хуулийн 10 дугаар зүйлд заасан концессын зүйлийн жагсаалтад орсон байх;
  - Концессын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтаар хэрэгжүүлэгч нь шалгарч, тус хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу концессын гэрээ хийгдсэн байх;
- г. Гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх
- д. Хөгжлийн банкны санхүүжилтээр санхүүжүүлэх
- Санхүүжилт хүссэн дүн нь 20.0 тэрбум төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш байх;
  - Төслийн нийт өртгийн 15%-аас доошгүй хувийг төсөл хэрэгжүүлэгчийн эсхүл бусад хөрөнгө оруулагч, банк санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр бүрдүүлэх боломжтой байх;
  - Төсөл, хөтөлбөр нь экспортыг дэмжсэн байх;
  - Техник-эдийн засгийн үндэслэл хийгдсэн байх;
  - Байгаль орчны стратегийн үнэлгээ эсхүл байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдэж эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;
  - Төслийн хүрээнд баригдах барилга байгууламжийн зураг төсөл, төсөв хийгдэж, магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргуулсан байх;
  - Төсөл, хөтөлбөр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжихээр байх;

## ДОЛОО. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ТОДОРХОЙЛОХ

- 7.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төслийн саналын Хавсралт 10 маягтын дагуу төслийн хэрэгжилтийн явц болон төслийг хэрэгжүүлэхэд учирч буй саад, бэрхшээл, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээллийг хүргүүлнэ.

- 7.2. УХОХ-т туссан төслийн хэрэгжилтийг ажлын явц болон санхүүжилтийн гүйцэтгэл гэсэн 2 хэсгээр, төслийн зорилго, зорилт нэг бүрээр тодорхойлно.
- а. Ажлын явц – төслийн зорилго, зорилтын биөлэлтийн байдал, төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын танилцуулга, шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшин, хүрэх үр дүнд хүрч байгаа эсэх, учирч буй саад бэрхшээл, эрсдэл зэргийг тайлагнана.
- б. Санхүүжилтийн гүйцэтгэл – төслийн төлөвлөлтийн шатанд тавьсан зорилт тус бүрээр санхүүжилтийн гүйцэтгэлийг тайлагнана.

---оOо---

## ХАВСРАЛТУУД

### Хавсралт 1. Төслийн үндсэн мэдээлэл

Төслийн үндсэн мэдээлэл		
№	Үзүүлэлт	Таницуулга
1	Төслийн нийт	
2	Төсөл хэрэгжүүхийн салбэр	
3	Төсөл хэрэгжүүхийн дад салбар	
4	Төсөл хэрэгжүүхийн байршил	Аймаг, хот Сум, дүүрэг Хаяг
5	Төслийн үндэслэл, шаардлага	
6	Төслийн таницуулга	
7	Төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгуулалт / тоног төхөөрөмж / үйл ажиллагаа	
8	Хөрөнгө оруулалтвар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ	Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс агуулга, зах зээлийн энээлжийн төлөв байдал Нийгмийн эрэлт хэрэцээ, шаардлага Эдийн засгийн эрэлт, хэрэцээ, шаардлага Дад бүтээгдэхүүн хэрэцээ, шаардлага
9	Бүтээн байгуулалтын зардлын эх үүсвэр	
10	Төслийн нийт төсөөт өртөг: /сая,төгрөгөөр илрхийлэх ба төслийн нийт төсөөт өртөгийн дун байна/	
11	Төслийн болон ашиглалтын хүчин чадал/хүчин чадлыг хэмжих нээжилгээ тодорхой оруулна/	Төслийн нийт хүчин чадал болон хэмжийн нэгж
		Төлевэлж буй ашиглалтын хүчин чадал /төлевэлж буй ашиглалтын хүчин чадлыг он сноор авсан хэмжих нээжилгээ (көтөлөө, тн/бөр) в.м тодорхой оруулна./
12	Төслийн хэрэгжүүхийн хугацаа	Бүтээн байгуулалт  Ашиглалтанд орсноос хойш
		Нийт хугацаа: ..... жилийн Эхлах он: ..... Дуусах он: .....
13	Хөгжлийн бодлогоын зорилго, зорилттой нийцэх байдал	Урт хугацааны хөгжлийн бодлого  10 хүртэлж жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого  5 хүртэлж жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого  Бус, орон иуттийн хөгжлийн бодлого
14	Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	УХОХ-т газар зүйн буюуд төсөлүүд, ярийн ажлыгийн үзүүлэлт Овдадаи  УХОХ-т тусаагүй төсөл, арга хэмжээтэй уялдах байдал
15	Хүрээлэн буй орчны үзүүлэлт нийтоо	Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн төгтолцоо  Газар чөлөөлөлт
16	Төслийн зорилго, зорилт	Эрхэм зорилго Төслийн зорилго Зорилт 1 Зорилт 2 Зорилт 3 Зорилт 4
17	Санхүүгийн үзүүлэлтүүд	Санхүүгийн шинжилгээний үзүүлэлт 1 FIRR Санхүүгийн төгөөжийн дотоод хувь Санхүүгийн шинжилгээний үзүүлэлт 2 NPV (Financial analysis) Цэвэр энээлжийн үнс цэнэ (Санхүүгийн) Санхүүгийн шинжилгээний үзүүлэлт 3 B/C Үр ашиг, зардлын харьцаа (Санхүүгийн)  Эдийн засгийн шинжилгээний үзүүлэлт 1 EIRR Эдийн засгийн төгөөжийн дотоод хувь Эдийн засгийн шинжилгээний үзүүлэлт 2 NPV (Economic analysis) Цэвэр энээлжийн үнс цэнэ (Эдийн засгийн) Эдийн засгийн шинжилгээний үзүүлэлт 3 B/C Үр ашиг, зардлын харьцаа (Эдийн засгийн)

			Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулжад үзүүлэх нелэв	
			Хүний эрүүл, урт удсан вмьдражад үзүүлэх нелэв	
			Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшүүлжээд үзүүлэх нелэв	
			Иргэдийн эрүүл, аюулгүй, зохицой орчинд вмьдрас нахцлийг бурдүүлжээд үзүүлэх нелэв	
			Үндэсний унэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгоход үзүүлэх нелэв	
18	Төслийн нийгэм, здийн засгийн үр ашиг	Нийгмийн үч холбогдол	ЗУАТ-нд дурдагдсан нийгмийн үч холбогдлын үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангах эсэх	
		Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өвөөж	Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлжээд үзүүлэх нелэв	
			Экспортыг дэмжжөс импортыг орлоход үзүүлэх нелэв	
			Ажлын байрыг нэмэгдүүлжээд үзүүлэх нелэв	
			Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлжээд үзүүлэх нелэв	
			Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлжээд үзүүлэх нелэв	
			ЗУАТ-нд дурдагдсан здийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өвөөжийн үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангах эсэх	
19	Хууль, эрх зүйн орчин			
20	Бүтэц, зохион байгуулалт			
21	Шинэ технологи, инноваци шингэсэн байдал			
22	Холбогдох судалгаа, шинжилгээ		оСуурь судалгаа оБодлогын судалгаа оТЭЭСУ оТЭЭҮ оЗураг төсөл оБОНБҮ (еренжийн нарийвчилсан) оГазрын зөвшөөрөл оХолбогдох тусгай зөвшөөрлүүд оГэрээ оБусад / /	
23	Дэд бүтцийн хэрэгцээ		/Төсөл хэрэгжих байршилд байгаа дэд бүтцийг ашиглах бол/ оЭрчим хүч оДулаан оЦэвэр ус оТехнологийн сэЦэвэрлэх байгууламж оАриуттах татуурга оМэдээлэл, харилцаа холбоо оАвтозам оТемер зам оБусад / /	
24	Хэрэгжих боломж	Нийт төслийн үндэслэл, хэрэгжих боломж	/Төсөл хэрэгжих байршилд одоо байгаа дэд бүтцийг өргөтгэх эсвэл шинээр байгуулах бол/ оЭрчим хүч оДулаан оЦэвэр ус оТехнологийн сэЦэвэрлэх байгууламж оАриуттах татуурга оМэдээлэл, харилцаа холбоо оАвтозам оТемер зам оБусад / /	
25	Эрсдэл	Төслийн эрсдэлийн түвшний үнэлгээ		

**Хавсралт 2. Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин**

Nº	Үзүүлэлт	Нийцэх байдал	Хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох заалт	Бодлогын зорилго, зорилтыг хангахад үзүүлэх нэлээ	Төслийн хэрэгцээ шаардлагатай
<b>Хөгжлийн бодлогын баримт бичийн зорилго, зорилтой нийцэх байдал</b>					
1	Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтой нийцэх байдал				
2	10 хуртгای жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтой нийцэх байдал				
3	5 хуртгайжилтийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтой нийцэх байдал	Дунд			
4	Бус, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилтой нийцэх байдал				
Nº	Үзүүлэлт	Үзүүлэлт байдал	Үзүүлэлт байдал арга хэмжээний нэр	Бусад төсөл, арга хэмжээний яоч, товч агуулга	Үзүүлэлт байдал арга хэмжээтэй уялдаа, хамварал
<b>Бусад төсөл, арга хэмжээтэй уялдаа, хамварал</b>					
1	УХОХ-т туссан тухайн салбар, бус орон нутаг дахь бусад төсөл, арга хэмжээтэй уялдаа эсэх				
2	УХОХ-т тусаагүй тухайн салбар, бус орон нутаг дахь төсөл, арга хэмжээтэй уялдаа эсэх				
3	Уялдан хэрэгжих ямар нэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байгүй бол энэ тухай тодорхой тайлбарлах				
Nº	Үзүүлэлт	Бэлэн байдал	Хууль эрх зүйн акт, холбогдох тушаал шийдвэр	Хүчин төгөлдөр байдал	Төслийн хэрэгжилтэд үзүүлэх нэлээ
<b>Төслийн үндэслэл, хууль эрх зүйн орчин</b>					
1	Хууль эрх зүйн шаардлагад нийцэж буй байдал, төслийн үндэслэл	Хараахан бэлэн бус			

**Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөөлөгч**

Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөөлөгч									
Бүтээн байгуулалтын үе шат									
№	Үндсэн ажлууд	Нийт төлөвлөлтийн/Ерөнхий үнэлгээ/Тайлбар			Өнгөрсөн хугацааны төслийн явц Түргэмдэж буй асуудал		Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө/Бүтэц зохион байгуулалтийн/ Эрсдэл		Тайлбар
		20-- он	20-- он	20-- он	20-- он	20-- он	20-- он		
	Он иноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөөлөгч								
	Төслийн бүтэц, зохион байгуулалтын балан байдал								
	Шинэ технологи								
	Учирч болох эрсдэл								
	Эрсдэл бууруулах арга хэмжээ								
№	Үндсэн ажлууд	Нийт төсөвт ортог (сая тог.)	Төлөвлөж буй эз уусвар	Урьдчилсан санхүүжилт	Өнгөрсөн хугацаанд хийгдсэн санхүүжилт		Санхүүжилтийн төлөвлөгөө/ Батлагдсан төсөв		Тайлбар
					20-- он	20-- он	20-- он	20-- он	
1	Тоног төхөөрөмж								
2	Барилга								
3	Цалин хөлс								
4	Бусад								
5	.....								
Нийт									
Төлөвлөж буй санхүүжилтийн хувь									
* Өнгөрсөн хугацаанд ямар нэг санхүүжилт хийгдсэн бол гүйцэтгэл гарсан он сар өдөр, эх уусварын тайлбар хэсэгт тодорхой тусгах шаардлагатай.									
<b>Ашиглалтанд орсноос хойш</b>									
№	Үндсэн ажлууд	Ерөнхий үнэлгээ/ Тайлбар	Жилийн хүчин чадал	Хэмжийн нэгж	Үйл ажиллагааны төлөвлөгөө/ Эрсдэл				Бүтээгдэхүүн, үүлчилгээний Нэр
					20-- он	20-- он	20-- он	20-- он	
	Он иноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөөлөгч								
	Учирч болох эрсдэл								
	Эрсдэл бууруулах арга хэмжээ								
№	Үндсэн ажлууд	Нийт төсөвт ортог/ Нийт хүчин чадал	Төлөвлөж буй эз уусвар	Урьдчилсан санхүүжилт	Үйл ажиллагааны үе шатны санхүүжилтийн төлөвлөгөө/ Төлөвлөж буй эз уусварын хүчин чадал				Тайлбар
									20-- он
1	Тоног төхөөрөмж								
2	Барилга								
3	Цалин хөлс								
4	Бусад								
5	.....								
Нийт									
Төслийн хүрээнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ									

**Хавсралт 4. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт								
№	Зорилтууд	Шалгуур үзүүлэлтийн түвшин	Үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэр	Тайлбар	Сүүрь түвшин. өмнөх оны хэрэгжилт	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн		
						Toon үзүүлэлт	Чанарын үзүүлэлт	Toon үзүүлэлт
						Чанарын үзүүлэлт	Чанарын үзүүлэлт	Чанарын үзүүлэлт
1	.....	Эрхэм зорилго						
2	.....	Төслийн зорилго						
3	.....	Зорилт 1						
4	.....	Зорилт 2						
5	.....	Зорилт 3						
6	.....	Зорилт 4						

*Хавсралт 5. Төслийн урьдчилсан судалгаа, гэрзэх хэлийн*

**Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл**

№	Судалгаа шинжилгээний ажил, холбогдох тэрээ хэлцэл	Хийгдсэн эсэх	Танилцуулга
1	Суурь судалгаа:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
2	Бодлогын судалгаа:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
3	ТЭЗҮС:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
4	ТЭЗҮ:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
5	Зураг төсөл:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
6	Байгаль орчны ерөнхий / нарийвчилсан үнэлгээ:	Хийгдээгүй бол шалтгаан тайлбар:  Хийгдсэн бол:	.....  Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
		Хүрээлэн буй орчинд зэлтэй технологи  Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоо	
7	Газрын асуудал шийдвэргэсэн эсэх	Үгүй бол шалтгаан, тайлбар:	.....
		Тийм бол	Гэрчилгээний дугаар:  Гэрчилгээний төрөл: а) зээмших б) ашиглах в) эмчлэх  Гэрчилгээ олгосон огноо: Он: ..... Сар: ..... Өдөр: .....
			Гэрчилгээ дуусах огноо: Он: ..... Сар: ..... Өдөр: .....
			Шийдвэр гаргасан:  Аймаг /нийслэл/: ..... Сум, дүүрэг: ..... Албан тушаал: ..... Нэр: .....

		Аваагүй бол шалтгаан, тайлбар:	.....
8	Холбогдох тусгай зөвшөөрлүүд:	Авсан бол:	Тусгай зөвшөөрлийн нэр: ..... /авшиялалтын лиценз, паркийн үйл ажиллагаа эрхлэх тусаад зөвшөөрөл а.м./ Тусгай зөвшөөрлийн дугаар: ..... Тусгай зөвшөөрөл олгосон огноо: .....
9	Бусад: /инженер, геологийн судалгаа, хөрсний шинжилгээ, усны шинжилгээ г.м. тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа. Хэдэн ч ажил байж болно./		а) Судалгаа, шинжилгээний ажлын нэр: Гүйцэтгэсэн байгууллагын нэр: Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....
10	Байгуулсан гэрээ, хэлэлцээр: /бүтэгдэхүүн борлуулалтын, тоног төхөөрөмж эсвэл түүхий эд материал нийтийн, зөвлөх үйлчилгээний г.м. ямар нэг гэрээ, хэлэлцээр төслийн хүрээнд байгуулагдсан эсх талаарх мэдээлэл/		а) Гэрээний төрөл: ..... /зөвлөх үйлчилгээний, барилга угсралтын, тоног төхөөрөмж нийтийн г.м./ Гэрээлэгч байгууллагын нэр: ..... Гэрээ хийгдсэн огноо: ..... Гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал: ..... Гэрээний үр дүн: .....
			б) Гэрээний төрөл: ..... /зөвлөх үйлчилгээний, барилга угсралтын, тоног төхөөрөмж нийтийн г.м./ Гэрээлэгч байгууллагын нэр: ..... Гэрээ хийгдсэн огноо: ..... Гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал: ..... Гэрээний үр дүн: .....

**Хавсралт 6. Төслийн дэд бүтцийн хэрэгзээ**

Төслийн дэд бүтцийн хэрэгзээ							
Дэд бүтэц шаардлагатай эсэх:							
№	Дэд бүтэц	Хэмжих нэгж	Нийт хэрэгцээ	Одоогийн баядал	Өргөтгөх/Цынээр барих	Техникийн нэхцэл авсан эсэх	Тайлбар
1	Эрчим хувьн хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
2	Дулган хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
3	Азуйн ус хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
4	Технологийн ус хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
5	Цэвэрээх байгууламж, армулах татуурга					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
6	Мэдрэгэл, харилцах холбоо					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
7	Авто зам					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
8	Темер зам					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	
9	Бусад					Аваагүй бол шалтгаан, тайлбар: ..... Техникийн нэхцэлийн дугаар: ..... Техникийн нэхцэлийн оноо: .....	

**Хавсралт 7. Нийгэм, эдийн засгийн үр ашигийн шинжилгээ**

<b>Нийгэм, эдийн засгийн үр ашигийн шинжилгээ</b>									
<b>(1) Нийгмийн ач холбогдол</b>									
1 Төреес олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайкруулахад нэлэөлөх үү?									
Тайлбар:									
2 Хүний эрүүл, урт удаан амьдрахад нэлэөлөх үү?									
Тайлбар:									
3 Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэхэд нэлэөлөх үү?									
Тайлбар:									
4 Иргэдийн эрүүл, аюулгүй, зохицой орчинд амьдрах нөхцлийг бурдүүлэхэд нэлэөлөх үү?									
Тайлбар:									
5 Үндэсний унэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгоход нэлэөлөх үү?									
Тайлбар:									
6 ЗУАТ-нд дурдагдсан нийгмийн ач холбогдлыг илтгэх үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангасан уу?									
Тайлбар:									
<b>(2) Эдийн засгийн үр ашиг</b>									
1 Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх үү?									
Бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ		20-- он	Нийт						
		Хэмжээ Мөнгөн дүн							
Тайлбар:									
2 Экспортыг дэмжих, импортыг орлоход нэлэөлөх үү?									
Экспорт, импорт		Бүтээгдэхүүн		20-- он	Нийт				
				Хэмжээ Мөнгөн дүн	Хэмжээ Мөнгөн дүн	Хэмжээ Мөнгөн дүн	Хэмжээ Мөнгөн дүн	Хэмжээ Мөнгөн дүн	Хэмжээ Мөнгөн дүн
Тайлбар:									

3 Ажлын байрыг нэмэгдүүлэхэд нөлөөлех уу?									
<b>Бүтээн байгуулалтын үе шат</b>									
<b>№</b>	<b>Мэргэжлийн чиглэл</b>	<b>Шууд ажлын байр</b>				<b>Шууд бус ажлын байр</b>			
		<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>	<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>				
T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2		
1 Удирдах ажилтан									
2 Инженер технологийн ажилчид									
3 Мэргэжлийн ажилчид									
4 Бусад ажилчид									
Нийт									
<b>Үйл ажиллагааны үе шат</b>									
<b>№</b>	<b>Мэргэжлийн чиглэл</b>	<b>Шууд ажлын байр</b>				<b>Шууд бус ажлын байр</b>			
		<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>	<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>				
T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2		
1 Удирдах ажилтан									
2 Инженер технологийн ажилчид									
3 Мэргэжлийн ажилчид									
4 Бусад ажилчид									
Нийт									
Тайлбар:									

  

4 Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлех уу?									
<b>Бүтээн байгуулалтын үе шат</b>									
<b>№</b>	<b>Мэргэжлийн чиглэл</b>	<b>Шууд ажлын байр</b>				<b>Шууд бус ажлын байр</b>			
		<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>	<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>				
T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2		
1 Удирдах ажилтан									
2 Инженер технологийн ажилчид									
3 Мэргэжлийн ажилчид									
4 Бусад ажилчид									
Нийт									
<b>Үйл ажиллагааны үе шат</b>									
<b>№</b>	<b>Мэргэжлийн чиглэл</b>	<b>Шууд ажлын байр</b>				<b>Шууд бус ажлын байр</b>			
		<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>	<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>				
T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2		
1 Удирдах ажилтан									
2 Инженер технологийн ажилчид									
3 Мэргэжлийн ажилчид									
4 Бусад ажилчид									
Нийт									
Тайлбар:									

  

5 Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлех уу?							
<b>Хөрөнгө оруулах объект</b>	<b>Толөвлөж буй хөрөнгө оруулагч</b>	<b>20-- он</b>	<b>Нийт</b>				
		Хэмжээ дун	Хэмжээ дун				
Тайлбар:							

  

6 ЗУАТ-нд дурдагдсан эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг илтгэх үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангасан уу?							
Тайлбар:							

Хавсралт 8. Санхүүгийн шинжилгээ

Санхүүгийн шинжилгээ								
Параметр:	ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь:			%				
Хугацаа	Хөрөнгө оруулалт	Ашиглалт, засвар үүлчилгээ	Нийт өртөг	Нийт орлого	Цэвэр орлого/Алдагдал	Хорогдуулсан мөнгөн ургал		
	Зардал	Зардал				Зардал	Орлого	Цэвэр орлого
2021								
2022								
2023								
2024								
2025								
2026								
2027								
2028								
2029								
2030								
2031								
2032								
2033								
2034								
2035								
2036								
2037								
2038								
2039								
2040								
2041								
2042								
2043								
2044								
2045								
2046								
2047								
2048								
2049								
2050								
2051								
2052								
2053								
2054								
2055								
2056								
Нийт	0	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн өгөөжийн дотоод хувь			Сөдх:		ЦӨҮЦ (сая төг):	0.00		
Үр ашиг, зардлын харьцаа			ҮАЗХ:					

Хөвсралт 9. Эдийн засгийн шинжилгээ

Эдийн засгийн шинжилгээ								
Параметр:	ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь:		%					
Хугацаа	Хөрөнгө оруулалт	Ашиглалт, засвар үйлчилгээ	Нийт өртөг	Нийт үр ашиг	Цэвэр үр ашиг/Алдагдал	Хорогдуулсан мөнгөн ургал		
	Зардал	Зардал				Зардал	Үр ашиг	Цэвэр үр ашиг
2021								
2022								
2023								
2024								
2025								
2026								
2027								
2028								
2029								
2030								
2031								
2032								
2033								
2034								
2035								
2036								
2037								
2038								
2039								
2040								
2041								
2042								
2043								
2044								
2045								
2046								
2047								
2048								
2049								
2050								
2051								
2052								
2053								
2054								
2055								
2056								
Нийт	0	0	0	0	0	0	0	0
Эдийн засгийн өгөөжийн дотоод хувь			ЭЗӨДХ:		ЦӨҮЦ (сая төг):		0.00	
Үр ашиг, зардлын харьцаа			ҮАЗХ:					

Хөснэгт 10. Төслийн хэрэгжлийтийн тайлланын хүснэгт

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжлийн тайллангийн хүснэгт															
Төслийн нэр:															
Хэрэгжих хугацаа:															
<b>Ажлын явц</b>															
Төслийн зорилт, зорилт	Шалгур үзүүлэлт	Төслийн ажлын явц					Нийт ажлын явц, хувь (%)	Нийт төсөвт өртөг	Эх үүсээр	Санхүүжилтийн гүйцэтгэл					
		Суур түвшин (20-оны эцслэл)	20-оны хэрэгжилт			Санхүүжилт /сая тог./				Суурь оны санхүүжилт хийдсэн дүн (20-оны эцслэл)	20-оны гүйцэтгэлийн дүн	20-оны санхүүжилт			Нийт гүйцэтгэн, хувь (%)
			20-оны хэрэгжилт, явл. (%)	20-оны төлөвлөсөн	20-оны бигалт							20-оны хэрэгжилт, явл. (%)	20-оны төсөв	20-оны гүйцэтгэл	
Төслийн зорилго						Нийт өртөг									
Зорилт 1						Зорилт 1-ийн санхүүжилт									
Зорилт 2						Зорилт 2-ийн санхүүжилт									
Зорилт *						Зорилт *-ийн санхүүжилт									
						Нийт дүн									
20-оны төслийн ажлын явлын үзлэгээ <sup>1</sup>	%	Ажлын явц, тайлбар						20-оны санхүүжилтийн гүйцэтгэлийн үзлэгээ <sup>1</sup>	%	Санхүүжилтийн гүйцэтгэл, тайлбар					
		Төслийн зорилго, зорилтыг биелүүлэхэд учирч буй сад бэрхшээл, зредэл								Төслийн санхүүжилтийн холбоотой учирч буй сад бэрхшээл, зредэл					
ТЭЗ-ийн нэгдсэн дунгали <sup>2</sup>		<input type="checkbox"/> Харилцок дуссан. <input checked="" type="checkbox"/> Үргэлжлүүлж. <input type="checkbox"/> Эргэлзээж, дэлж үзж.		Нэмэлт тайлбар:											
<p><b>*Жил:</b></p> <p>1. Энэ хэсийн үзлэгээ төслийн ерөнхийлен захиргачийн хяналт-шишигтэй, үзлэгээ харилцсан албан хаагч Засгийн газрын холбогдох журмын заасан хяналт-шишигтэй, үзлэгээний арга зүйд үзүүлсэн хөжүүлэгтэн.</p> <p>2. Төслийн ерөнхийлен захиргач нь төслийн ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэлийн хувьас гадна тухайн төслийн хэрэгжүүлэхэд учирч буй сад, бэрхшээл, зредэлт хүчин зүйлс зэрэг харгалзан нэгдсэн дунгалийг гаргана. Төслийн төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд өөрчилж орсон тохиолдод тухайн төслийн эргэлзээтэй буюу дахин үзэхэд антлагддэг оруулж холбогдох арга жиёсэг авна. Дахин үзэхэд аргачлаал нь Санчийн сайдын 295 дугаар тушаалыар батлагдсан "Улсын төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үзэхэд аргачлаа" тайвуддана.</p>															

